



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2024/29/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Санжаажав**

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2024 он

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА С.ПҮРЭВСАМДАН ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

№ \_\_\_\_\_  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Шадар сайдын 2021 онд баталсан аймаг, нийслэлд гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах төлөвлөгөө, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дархан-Уул аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс 18-ны өдрийн хооронд зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 488, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоожээ. Мөн Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар тэмдэглэлээр цалингийн сангийн хэмнэлтээс ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан үзэж нэг сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар тооцож урамшуулахаар шийдвэрлэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 92.0 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

009020010

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МӨНХБАЯР



9022899  
917143826



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,711,058,972.36</u></b>	<b><u>1,202,010,025.79</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,711,058,972.36</b>	<b>1,202,010,025.79</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>18,030,594.98</b>	<b>16,178,019.83</b>
35130	Эм боох материал	18,030,594.98	16,178,019.83
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>680,746,693.12</b>	<b>833,744,781.67</b>
35410	Бичиг хэргийн материал	7,551,445.00	8,162,035.00
35420	Аж ахуйн материал	45,706,046.72	53,746,819.72
35430	Сэлбэг хэрэгсэл	32,802,500.00	43,112,572.00
35440	Түлш, шатах тослох материал	9,453,437.32	16,361,756.74
35460	Хүнсний материал	9,306,153.11	1,250,000.00
35470	Бусад хангамжийн материал	575,927,110.97	711,111,598.21
35600	Нормын хувцас	1,012,281,684.26	352,087,224.29
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>17,629,461,563.57</u></b>	<b><u>16,895,873,984.82</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>17,629,461,563.57</b>	<b>16,895,873,984.82</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>12,188,403,063.57</b>	<b>11,454,843,984.82</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,701,231,802.12	9,701,231,802.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,571,162,367.83)	(2,828,045,840.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,648,529,110.65	8,188,729,110.65
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,638,226,659.15)	(4,469,020,310.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,200,282,125.64	1,333,782,125.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(918,835,664.80)	(1,089,795,883.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,432,867.74	39,432,867.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,204,549.87)	(26,089,486.70)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,209,502,993.87	1,295,928,764.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	(464,146,594.80)	(691,309,164.51)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,441,058,500.00</b>	<b>5,441,030,000.00</b>
39301	Програм хангамж	114,000.00	114,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(85,500.00)	(114,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,441,030,000.00	5,441,030,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>19,340,520,535.93</u></b>	<b><u>18,097,884,010.61</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,410,369.95</u></b>	<b><u>4,341,569.95</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,410,369.95</b>	<b>4,341,569.95</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>3,410,369.95</b>	<b>4,341,569.95</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,410,369.95	3,410,369.95
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>931,200.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	931,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>19,337,110,165.98</u></b>	<b><u>18,093,542,440.66</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>19,337,110,165.98</b>	<b>18,093,542,440.66</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,656,526,626.23	6,656,526,626.23
51101	Өмч: - төрийн	6,656,526,626.23	6,656,526,626.23
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>8,541,346,623.47</b>	<b>7,297,778,898.15</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	9,807,614,670.52	8,541,346,623.47
51220	Тайлант үеийн үр дүн	(1,266,268,047.05)	(1,243,567,725.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,139,236,916.28	4,139,236,916.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>19,340,520,535.93</u></b>	<b><u>18,097,884,010.61</u></b>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,888,765,932.00</b>	<b>5,441,555,523.58</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>629,627,732.00</b>	<b>1,232,962,283.58</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>629,627,732.00</b>	<b>1,232,962,283.58</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	629,627,732.00	1,232,962,283.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,361,899.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	629,627,732.00	1,200,600,384.58
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,259,138,200.00</b>	<b>4,208,593,240.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,119,540,000.00</b>	<b>3,902,003,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,119,540,000.00	3,902,003,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>139,598,200.00</b>	<b>306,589,540.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	104,071,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,398,700.00	141,117,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,059,500.00	49,729,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,140,000.00	11,671,540.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,155,033,979.05</b>	<b>6,685,123,248.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,155,033,979.05</b>	<b>6,685,123,248.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,143,071,317.52</b>	<b>6,641,395,383.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,646,798,833.00</b>	<b>3,431,900,200.00</b>
210101	Үндсэн цалин	1,750,578,783.00	1,836,876,100.00
210102	Нэмэгдэл	861,881,700.00	1,435,351,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,557,400.00	78,557,400.00
210104	Урамшуулал	-	81,115,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>99,944,300.00</b>	<b>111,549,473.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,398,400.00	23,514,322.59
210202	Тэтгэмжийн даатгал	3,693,400.00	2,758,531.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,956,300.00	2,206,744.81
210204	Ажилгүйдлийн даатгал	739,500.00	551,786.20
210205	Эрүүл мэндийн даатгал	61,156,700.00	82,518,088.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>110,201,480.95</b>	<b>140,428,018.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	42,851,400.00	53,763,799.59
210302	Түлш, халаалт	61,681,480.95	76,598,919.05
210303	Цэвэр, бохир ус	5,668,600.00	10,065,299.38
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>127,130,587.14</b>	<b>114,037,352.96</b>
210401	Бичиг хэрэг	16,971,410.00	7,400,210.00
210402	Тээвэр, шатахуун	105,476,664.14	102,691,320.58
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,538,113.00	3,875,022.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	144,400.00	70,800.00



	мэрэгчдийн устгал, ариутгал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>136,222,498.00</b>	<b>137,282,336.82</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,312,454.00	5,421,783.71
210502	Хоол, хүнс	125,910,044.00	131,860,553.11
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>56,563,917.00</b>	<b>30,882,226.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,703,913.00	-
210604	Урсгал засвар	40,860,004.00	30,882,226.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>38,119,600.00</b>	<b>72,389,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	38,119,600.00	72,389,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>36,142,543.00</b>	<b>42,870,033.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,573,980.00	24,215,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,375,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,451,900.00	2,062,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	517,000.00	869,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	980,000.00	1,233,300.00
210807	Газрын төлбөр	14,244,463.00	14,489,425.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,887,728,508.43</b>	<b>2,560,056,743.57</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,922,871.06	1,106,203,394.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,076,880.00	26,890,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,757,728,757.37	1,426,963,349.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,962,661.53</b>	<b>43,727,865.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,380,000.00</b>	<b>7,050,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,380,000.00	7,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,582,661.53</b>	<b>36,677,865.40</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,582,661.53	36,677,865.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(1,266,268,047.05)</u></b>	<b><u>(1,243,567,725.32)</u></b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(1,266,268,047.05)</u></b>	<b><u>(1,243,567,725.32)</u></b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,260,138,356.30</u></b>	<b><u>4,240,955,139.00</u></b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,156.30	32,361,899.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,156.30	32,361,899.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	32,361,899.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,361,899.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,259,138,200.00</b>	<b>4,208,593,240.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,119,540,000.00	3,902,003,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,119,540,000.00	3,902,003,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>139,598,200.00</b>	<b>306,589,540.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	104,071,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,398,700.00	141,117,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,059,500.00	49,729,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,140,000.00	11,671,540.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,195,354,656.30</u></b>	<b><u>4,240,955,139.00</u></b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,195,354,656.30	4,240,955,139.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,183,391,994.77	4,196,227,273.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,651,017,883.00	3,431,900,200.00
210101	Үндсэн цалин	1,750,578,783.00	1,836,876,100.00
210102	Нэмэгдэл	861,881,700.00	1,435,351,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,557,400.00	78,557,400.00
210104	Урамшуулал	-	81,115,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,944,300.00	111,549,473.13
210201	Тэтгэврийн даатгал	31,398,400.00	23,514,322.59
210202	Тэтгэмжийн даатгал	3,693,400.00	2,758,531.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,956,300.00	2,206,744.81
210204	Ажилгүйдлийн даатгал	739,500.00	551,786.20
210205	Эрүүл мэндийн даатгал	61,156,700.00	82,518,088.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,231,799.47	139,884,923.02
210301	Гэрэл, цахилгаан	42,851,400.00	53,763,799.59
210302	Түлш, халаалт	58,711,799.47	76,055,824.05
210303	Цэвэр, бохир ус	5,668,600.00	10,065,299.38
2104	Хангамж, бараа материалын зардал	23,322,413.00	15,005,462.38
210401	Бичиг хэрэг	14,829,100.00	6,231,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,810,800.00	4,828,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,538,113.00	3,875,022.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,400.00	70,800.00
2105	Нормативт зардал	122,105,700.00	129,267,100.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн	9,953,700.00	6,378,200.07



	хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	112,152,000.00	122,888,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>47,779,600.00</b>	<b>40,465,782.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,689,600.00	10,966,600.00
210604	Урсгал засвар	38,090,000.00	29,499,182.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>38,119,600.00</b>	<b>71,389,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	38,119,600.00	71,389,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,474,143.00</b>	<b>42,920,033.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,905,580.00	24,265,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,375,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,451,900.00	2,062,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	517,000.00	869,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	980,000.00	1,233,300.00
210807	Газрын төлбөр	14,244,463.00	14,489,425.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,896,556.30</b>	<b>213,845,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,387,156.30	186,955,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,509,400.00	26,890,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,962,661.53</b>	<b>44,727,865.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,380,000.00</b>	<b>8,050,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,380,000.00	8,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,582,661.53</b>	<b>36,677,865.40</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,582,661.53	36,677,865.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>87,283,700.00</u></b>	<b><u>-</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>87,283,700.00</u></b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>87,283,700.00</u></b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>87,283,700.00</b>	<b>-</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	87,283,700.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(87,283,700.00)</u></b>	<b><u>-</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>




2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>6,656,526,626.23</b>	<b>4,139,236,916.28</b>	<b>9,807,614,670.52</b>	<b>20,603,378,213.03</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>6,656,526,626.23</b>	<b>4,139,236,916.28</b>	<b>9,807,614,670.52</b>	<b>20,603,378,213.03</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,266,268,047.05)	(1,266,268,047.05)
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,656,526,626.23</b>	<b>4,139,236,916.28</b>	<b>8,541,346,623.47</b>	<b>19,337,110,165.98</b>
D01	<b>2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>6,656,526,626.23</b>	<b>4,139,236,916.28</b>	<b>8,541,346,623.47</b>	<b>19,337,110,165.98</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>6,656,526,626.23</b>	<b>4,139,236,916.28</b>	<b>8,541,346,623.47</b>	<b>19,337,110,165.98</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,243,567,725.32)	(1,243,567,725.32)
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,656,526,626.23</b>	<b>4,139,236,916.28</b>	<b>7,297,778,898.15</b>	<b>18,093,542,440.66</b>



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,924,269,400.00</b>	<b>3,897,687,733.60</b>	<b>(26,581,666.40)</b>	<b>99.3</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	3,924,269,400.00	3,897,687,733.60	(26,581,666.40)	99.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,916,175,000.00	3,889,637,733.60	(26,537,266.40)	99.3
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,431,900,200.00</b>	<b>3,431,900,200.00</b>	-	<b>100.0</b>
Үндсэн цалин	1,836,876,100.00	1,836,876,100.00	-	100.0
Нэмэгдэл	1,435,351,700.00	1,435,351,700.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	78,557,400.00	78,557,400.00	-	100.0
Урамшуулал	81,115,000.00	81,115,000.00	-	100.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>137,004,900.00</b>	<b>111,549,473.13</b>	<b>(25,455,426.87)</b>	<b>81.4</b>
Тэтгэврийн даатгал	31,102,200.00	23,514,322.59	(7,587,877.41)	75.6
Тэтгэмжийн даатгал	3,659,000.00	2,758,531.02	(900,468.98)	75.4
ҮОМШӨ-ний даатгал	2,927,200.00	2,206,744.81	(720,455.19)	75.4
Ажилгүйдлийн даатгал	731,800.00	551,786.20	(180,013.80)	75.4
Эрүүл мэндийн даатгал	98,584,700.00	82,518,088.51	(16,066,611.49)	83.7
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>139,889,500.00</b>	<b>139,884,923.02</b>	<b>(4,576.98)</b>	<b>100.0</b>
Гэрэл, цахилгаан	53,763,800.00	53,763,799.59	(0.41)	100.0
Түлш, халаалт	76,060,400.00	76,055,824.05	(4,575.95)	100.0
Цэвэр, бохир ус	10,065,300.00	10,065,299.38	(0.62)	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,188,900.00</b>	<b>6,116,822.38</b>	<b>(72,077.62)</b>	<b>98.8</b>
Бичиг хэрэг	2,242,800.00	2,171,000.00	(71,800.00)	96.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,875,300.00	3,875,022.38	(277.62)	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,800.00	70,800.00	-	100.0
<b>Нормативт зардал</b>	<b>127,767,200.00</b>	<b>127,767,100.07</b>	<b>(99.93)</b>	<b>100.0</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,878,300.00	4,878,200.07	(99.93)	100.0
Хоол, хүнс	122,888,900.00	122,888,900.00	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,500,000.00</b>	<b>29,499,182.00</b>	<b>(818.00)</b>	<b>100.0</b>
Урсгал засвар	29,500,000.00	29,499,182.00	(818.00)	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	-	-	-	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>43,924,300.00</b>	<b>42,920,033.00</b>	<b>(1,004,267.00)</b>	<b>97.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,265,700.00	24,265,700.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,475,700.00	2,062,608.00	(413,092.00)	83.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,133,000.00	869,000.00	(264,000.00)	76.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,233,300.00	1,233,300.00	-	100.0
Газрын төлбөр	14,816,600.00	14,489,425.00	(327,175.00)	97.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,094,400.00</b>	<b>8,050,000.00</b>	<b>(44,400.00)</b>	<b>99.5</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,094,400.00</b>	<b>8,050,000.00</b>	<b>(44,400.00)</b>	<b>99.5</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,094,400.00	8,050,000.00	(44,400.00)	99.5
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	-
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,924,269,400.00</b>	<b>3,907,783,932.60</b>	<b>(16,485,467.40)</b>	<b>99.6</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,902,003,700.00</b>	<b>3,875,422,033.60</b>	<b>(26,581,666.40)</b>	<b>99.3</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,902,003,700.00	3,875,422,033.60	(26,581,666.40)	99.3
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>22,265,700.00</b>	<b>32,361,899.00</b>	<b>10,096,199.00</b>	<b>145.3</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,265,700.00	32,361,899.00	10,096,199.00	145.3



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>306,589,540.00</b>
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	306,589,540.00
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,589,540.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	8,888,640.00
210,401.00	Бичиг хэрэг	4,060,000.00
210,402.00	Тээвэр, шатахуун	4,828,640.00
2,105.00	Нормативт зардал	1,500,000.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,000.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	10,966,600.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	10,966,600.00
2,107.00	Томилолт, зочны зардал	71,389,000.00
210,702.00	Дотоод албан томилолт	71,389,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	213,845,300.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	186,955,300.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,890,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>306,589,540.00</b>
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	306,589,540.00
131,101.00	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	104,071,400.00
131,103.00	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,117,600.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,729,000.00
131,105.00	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,671,540.00
131,106.00	Төсвийн урамшуулал	-
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар нь гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэргэжлийн удирдлага зохицуулалтыг сайжруулах, хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх чиг үүрэг бүхий ОБЕГ-ын харьяа байгууллага юм.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар баталж, мөрдөж эхэлсэн бөгөөд салбарын онцлог, санхүүгийн программтай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлант Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,242,636.7 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	1,711,058.9	1,202,010.0	(509,048.9)
Үндсэн хөрөнгө	17,629,461.6	16,895,874.0	(733,587.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>19,340,520.5</b>	<b>18,097,884.0</b>	<b>(1,242,636.5)</b>
Өр төлбөр	3,410.4	4,341.6	931.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,337,110.1	18,093,542.4	(1,243,567.7)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>19,340,520.5</b>	<b>18,097,884.0</b>	<b>(1,242,636.5)</b>

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 307,390.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ОБЕГ-ын харьяа анги нэгтгэлээс 350,273.4 мянган төгрөгийн нормын хувцас, шатах тослох материал, аврах ажиллагааны багаж хэрэгсэл, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 42,275.4 мянган төгрөгийн ном, гарын авлага, анхны тусламжийн хайрцаг, галын хор, шланкны дагалдах хэрэгсэл, “Дархан Гео Маш” ХХК-аас 71,849.8 мянган төгрөгийн ролк, иргэн Л.Отгонбаяраас 38,150.0 мянган төгрөгийн транспортерын ремен, Дархан-Уул аймгийн Гаалийн газраас 3,376.0 мянган төгрөгийн усны гутал, “Кактус пэй” ХХК-аас 1,300.0 мянган төгрөгийн пос төхөөрөмж, нийт 507,224.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 1,323,771.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаар бараа материалын үлдэгдэл оны эцэст буурсан байна.

Үндсэн хөрөнгө 733,587.7 мянган төгрөгөөр буурахад хуримтлагдсан элэгдлийн өсөлт голлон нөлөөлжээ. Тодруулбал тайлант онд ОБЕГ-ын харьяа анги нэгтгэлээс аврах ажиллагаанд шаардлагатай 626,625.8 мянган төгрөгийн автомашин, аврах завь, зөөврийн мотопомп, бетон бутлагч зэрэг тоног төхөөрөмж, аймгийн ЗДТГ-аас 133,500.0 мянган төгрөгийн зөөврийн цахилгаан үүсгүүр зэргийг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 1,426,963.3 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Тайлант онд эцэст 4,341.6 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан. Үүнд өмнөх онд үүссэн “Горгаз” ХХК-ийн 3,410.4 мянган төгрөгийн шатахууны өр төлбөрийг барагдуулаагүй, бичиг хэргийн зардлын батлагдсан төсөв хүрэлцээгүйгээс “Мон-Өртөөчин” ХХК-нд 931.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,800,759.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 22,265.7 мянга, нийт 3,823,024.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ. Төсвийн төслийн саналаас 567,438.7 мянган төгрөгийг хасаж, 3,255,586.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн цалингийн зардлыг 79,912.5 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 6,916.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 54,593.3 мянга, хангамж, бараа материалын зардлыг 187,608.9 мянга, нормативт зардлыг 63,886.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 75,377.7 мянга, томилот, зочны зардлыг 7,440.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 69,546.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 44,084.2 мянга, бусад урсгал шилжүүлгийг 12,255.6 мянган төгрөгөөр тус тус бууруулжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 668,683.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Ингэхдээ Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардлыг 537,669.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 40,700.0 мянга, байр ашиглалтын тогтмол зардлын тариф өссөнтэй холбоотойгоор уг зардлыг 23,020.0 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,650.0 мянга, хоол, хүнсний зардлыг хагас жилээр тооцож төсөв баталсан байсныг тодотголоор нэмж өгсөнтэй холбоотойгоор нормативт зардлыг 67,923.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 6,238.2 мянган төгрөгөөр тус тус нэмж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 2,282.7 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,902,003.7 мянган төгрөг буюу 99.4 хувийг улсын төсвөөс, 22,265.7 мянган төгрөг буюу 0.6 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,902,003.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 32,361.9 мянган төгрөгийн орлого олжээ. Төсвийн зарлагын гүйцэтгэл 3,897,687.7 мянган төгрөг буюу 99.3 хувьтай бөгөөд зарцуулаагүй үлдсэн 36,677.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн 25,455.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 1,004.3 мянган төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдэж, үндсэн үйл ажиллагааны орлого 10,096.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>А</b>	<b>70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх</b>	<b>3,924,269.4</b>	<b>3,897,687.7</b>	<b>26,581.7</b>	<b>99.3</b>
1	80101"-Үндсэн үйл ажиллагааны зардал	3,893,909.3	3,867,372.0	26,537.3	99.3
2	"80103"- Гэрээгээр гүйцэтгэх ажил	22,265.7	22,265.7	-	100.0
3	"80802"-Ажил олгогчоос олгох тэтгэмж	8,094.4	8,050.0	44.4	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 306,589.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөв, төрийн болон төрийн бус этгээдээс авсан хандив тусламжийн орлогоос бүрдүүлж, зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна. Тодруулбал гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн зардалд аймаг, сумдын ЗДТГ-аас нийт 75,000.0 мянга, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулсан академик сургалтын зардал 104,071.4 мянга, Дархан суманд болсон үерийн гамшгийг арилгах, сэргээн засварлалтын зардал 55,151.0 мянга, гамшиг ослын томилолт 40,369.0 мянга, аймгийн ЗДТГ-аас цахилгаан эх үүсвэрийг дэд станцад холбох хэрэгслийн зардал 10,966.6 мянга, ахмадын сангийн санхүүжилт 9,360.0 мянга, аймгийн ИТХ-аас гадаад сургалтын зардалд 6,549.3 мянга, өсвөрийн аврагч буухиа тэмцээн зохион байгуулахад зориулж 1,800.0 мянга, Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийн үйл ажиллагаанд 1,000.0 мянга, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс “Хараа голын эргээр амарч буй иргэдийн аюулгүй байдлыг хангах”-д 2,322.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

#### **Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Санжаажав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн МН23/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 3,255,586.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,555.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

### **Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар 43,850.0 мянган төгрөгийн алдаа илрүүлэн аудитын явцад залруулж, 212,399.5 мянган төгрөгийн зөрчилд 2,225.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 210,174.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг бүрэн байршуулсан байв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 212,399.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 200,834.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 9,339.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,225.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	200,834.4	2	200,834.4	100
Албан шаардлага	1	9,339.7	1	9,339.7	100
Төлбөрийн акт	2	2,225.5	2	2,225.5	100
Нийт дүн	1	212,399.5	1	212,399.5	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,852,208.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад 2 алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх аудит хийсэн тайлангийн дүнтэй тулган шалгахад 16,840,842.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартын 53, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг залруулав.
2. Тайлант онд үүссэн 4,341.6 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь УСНББОУС 19 “Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө” стандартын 22, оршин байх батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул тооцоо нийлсэн актыг нөхөн бүрдүүлэлт хийлгэж залруулав.

Мөн аудитаар илэрсэн нийт 2,485.6 мянган төгрөгийн зөрчилд<sup>2</sup> 2,485.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хөрөнгө орлогод авах тухай албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд нийт 13 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэлд нийт 1,554.4 мянган төгрөг илүү тооцож олгосныг төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
- Тайлант онд батлагдсан төсвийг хэтрүүлэн 931.2 мянган төгрөг зарцуулсанд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

- Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 13,654.0 мкв талбайтай 2 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж<sup>3</sup>

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинжтэй 6 нэр төрлийн 7,024.3 мянган төгрөгийн үнэтэй хөрөнгийг бараа материал дансанд бүртгэж тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>3</sup> 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, НБББББ-т заасны дагуу бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх аудит хийсэн тайлангийн дүнтэй тулган шалгахад 16,840,842.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.	1	16,840,842.4			1	16,840,842.4	1	16,840,842.4				
Тайланд тусгасан 4,341.6 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	4,341.6			1	4,341.6	1	4,341.6				
Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг 7,024.3 мянган төгрөгийг холбогдох дансанд бүртгэх	1	7,024.3			1	7,024.3			1	7,024.3	1	7,024.3
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>16,852,208.3</b>			<b>3</b>	<b>16,852,208.3</b>	<b>2</b>	<b>16,845,184.0</b>	<b>1</b>	<b>7,024.3</b>	<b>1</b>	<b>7,024.3</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд нийт 13 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэлд нийт 1,554.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна	1	1,554.4	1	1,554.4								
Тайлант онд батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж 931.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна	1	931.2	1	931.2								
Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 13,654.0 мкв талбайтай 2 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгаагүй байв	1	-			1	-						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,485.6</b>	<b>2</b>	<b>2,485.6</b>	<b>1</b>	<b>-</b>						